

## **Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга**

1/Хуулийн төсөл боловсруулах зорилго, ач холбогдол:

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхээр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэхээр тусгасан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуулийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах зорилго, ач холбогдолтой:

- Валютын захын бүтэц зохион байгуулалт, гадаад валютын урсгал, гадаад валютын зах, арилжаанд оролцогчдод тавих хяналт, ханшийн хөөрөгдөл бий болох нөхцөл байдлаас сэргийлэх бодлого зохицуулалт, ханшийн хэлбэлзлийн эсрэг авах арга хэмжээ, гадаад валютын захад оролцогчийн хүлээх үүрэг хариуцлага, зэрэг тулгамдсан өнөөгийн асуудлыг цогцоор шийдвэрлэх;
- “Валютын зохицуулалтын тухай” хуулийн давхардал, зөрчил, хийдлийг бүрэн арилгах;
- “Валютын зохицуулалтын тухай”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулиудыг нэгтгэж, валютын нэгдсэн зохицуулалтыг бий болгох;
- Валютын харилцааг бүрэн зохицуулсан, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох;
- Гадаад секторын статистик, тоон мэдээллийн чанарыг олон улсын жишигт нийцүүлэх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэх харилцааг нэгтгэх, зарим хуулийн этгээдийн онцлогийг тусгах, хяналт, хариуцлагыг тодорхой болгох;
- Валютын нэгдсэн зохицуулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрхийг тодорхойлох.

2/ Хууль эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

Валютын зохицуулалтын тухай хууль нь 1994 оны 5 дугаар сарын 12-ны өдөр УИХ-аар батлагдсанаас хойш 22 жилийн хугацаанд 19 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд Хууль зүйн яамнаас “Валютын зохицуулалтын тухай” хуульд 2009 онд шинжилгээ хийн давхардал 3, зөрчил 18, хийдэл 30 гарч байна уг хуулийг нэн даруй

шинэчлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргаж байсан боловч одоог хүртэл шинэчлэгдээгүй байна.

### 3/ Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн макро эдийн засгийн бодлогын суурь нь хөрөнгийн чөлөөтэй урсгал, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэм болон төрийн мөнгөний бодлогын бие даасан байдал бөгөөд зохицуулах харилцаа нь эдийн засгийн харьяат хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын гүйлгээ, валютын дотоодын захын зохицуулалт төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэхтэй холбоотой харилцаа байна.

Шинэчилсэн найруулгын төсөл нь 7 бүлэг 21 зүйлтэй. Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэг: Валютын захын зохицуулалт, Гуравдугаар бүлэг: Гадаад гүйлгээ, төлбөр тооцооны зохицуулалт, Дөрөвдүгээр бүлэг: Тайлагнах, мэдээлэх, Тавдугаар бүлэг: Валютын зохицуулалтын талаар төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх бүрэн эрх, Зургаадугаар бүлэг: Хуулийн хэрэгжилтэнд тавих хяналт.

#### 1. Зохицуулах харилцаа:

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, эдийн засгийн харьяат хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын бүх төрлийн гүйлгээний эрх зүйн зохицуулалт, валютын дотоодын захын дэд бүтэц, мэдээллийн урсгалыг тодорхойлох, ханшийн механизм ажиллах, зах зээлийн мэргэжлийн оролцогчдын шударга өрсөлдөөнийг хангах нөхцлийг бүрдүүлэх замаар валютын зах үр ашигтай ажиллах эрх зүйн орчныг бий болгох, эрх бүхий төрийн байгууллагуудын дээрх харилцаанд оролцох эрх зүйн байдал, төрөөс явуулах хяналт, шалгалт, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

#### 2. Хамрах хүрээ:

Хуулийн төсөл нь Монгол Улсын эдийн засгийн харьяат болон харьяат буст хамаарна. Эдийн засгийн харьяат гэдэгт олон улсын стандартын дагуу дараах хуулийн этгээдүүд орно. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин суугч Монгол улсын иргэд,
- Гадаад оронд 1 жил хүртэл хугацаагаар түр оршин суугч Монгол улсын иргэд,
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин суугч гадаадын иргэд,
- Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага ба тэдгээрийн салбар, төлөөлөгчдийн газар,
- Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүд,

- Гадаад орнуудад сурч байгаа болон гадаадад урт болон богино хугацаагаар эмчлүүлж буй Монгол улсын иргэд

4/Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдон Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Валютын зохицуулалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгө тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан.

-----o0o----